



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсрол соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/167/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор:              П.Амаржаргал Утас: 88106992      Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	---

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	төгрөгөөр .. 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	төгрөгөөр .. 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	төгрөгөөр.. 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	төгрөгөөр.... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	төгрөгөөр .. 9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

᠒᠒.᠒.18 № 2/46

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ  
Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:\alban bichig\A4.docx


005020312

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

A handwritten signature in black ink is written over a red rectangular stamp. The stamp contains Mongolian text, including the word 'АУДИТОР' (Auditor) and 'МОНГОЛ' (Mongolia). The signature is a stylized, cursive script.

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>168,311,284.06</u></b>	<b><u>174,507,205.06</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	18,607,354.74	27,674,609.74
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	48,168.00	131,862.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	18,359,814.00	27,238,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	199,372.74	304,747.74
3351	Байгууллагаас авах авлага	199,372.74	304,747.74
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	0.00	1,571.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	0.00	1,571.00
34713	Цалингийн урьдчилгаа	0.00	1,571.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	149,703,929.32	146,831,024.32
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	135,000.00	135,000.00
35110	Тусгай зориулалттай материал	135,000.00	135,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	149,568,929.32	146,696,024.32
35410	Бичиг хэргийн материал	1,952,510.00	2,194,510.00
35420	Аж ахуйн материал	146,543,783.32	142,542,178.32
35430	Сэлбэг хэрэгсэл	540,000.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	1,426,700.00
35470	Бусад хангамжийн материал	532,636.00	532,636.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>318,115,744.22</u></b>	<b><u>827,233,389.33</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	318,115,744.22	827,233,389.33
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	95,445,827.53	535,658,472.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,267,100.00	503,823,250.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,267,100.00	-63,815,248.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	97,605,075.00	42,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-57,255,075.00	-10,950,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	121,119,478.33	138,797,502.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	-85,344,924.93	-79,525,734.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,682,234.57	18,890,394.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,025,085.64	-16,821,594.96
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,890,566.00	0.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19,886,343.30	0.00
39217	Ном	2,659,902.50	2,659,902.50
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	222,669,916.69	291,574,916.69
39301	Програм хангамж	6,104,000.00	16,104,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,391,083.31	-2,486,083.31
39303	Бусад биет бус хөрөнгө	217,957,000.00	277,957,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>486,427,028.28</u></b>	<b><u>1,001,740,594.39</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.18</b>	<b>760,900.18</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.18	760,900.18
<b>413</b>	<b>Өглөг</b>	0.18	760,900.18
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.18	760,900.18
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>486,427,028.10</u></b>	<b><u>1,000,979,694.21</u></b>

**Аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>486,427,028.10</b>	<b>1,000,979,694.21</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	423,939,977.83	483,939,977.83
51101	Өмч: - төрийн	423,939,977.83	483,939,977.83
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>44,664,333.13</b>	<b>499,216,999.24</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-40,892,425.01	44,664,333.13
51220	Тайлант үеийн үр дүн	85,556,758.14	454,552,666.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,822,717.14	17,822,717.14
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>486,427,028.28</b>	<b>1,001,740,594.39</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,578,562,498.00</b>	<b>2,996,411,083.12</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>128,204,048.00</b>	<b>536,433,591.12</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>128,204,048.00</b>	<b>536,433,591.12</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	42,600,000.00	463,859,071.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Материал	85,604,048.00	72,574,520.12
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,450,358,450.00</b>	<b>2,459,977,492.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,241,496,900.00</b>	<b>2,130,875,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,241,496,900.00	2,130,875,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>208,861,550.00</b>	<b>329,101,592.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	45,086,550.00	124,337,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	135,000,000.00	22,642,050.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,525,000.00	182,113,342.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,250,000.00	8,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,493,005,739.86</b>	<b>2,533,482,825.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,493,005,739.86</b>	<b>2,533,482,825.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>884,354,734.01</b>	<b>778,321,108.91</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>298,928,636.00</b>	<b>271,547,892.00</b>
210101	Үндсэн цалин	298,928,636.00	205,695,971.00
210102	Нэмэгдэл	0.00	42,714,665.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	15,766,700.00
210104	Урамшуулал	0.00	7,370,556.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,159,204.15</b>	<b>36,383,299.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,341,478.15	25,053,119.39
210202	Тэтгэмжийн даатгал	2,784,440.00	2,784,949.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,227,674.00	2,245,675.52
210204	Ажилгүйдлийн даатгал	541,379.00	580,150.16
210205	Эрүүл мэндийн даатгал	5,264,233.00	5,719,403.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,888,650.00</b>	<b>46,003,700.00</b>

**Аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210302	Түлш, халаалт	1,288,650.00	1,363,700.00
210304	Байрны түрээс	39,600,000.00	44,640,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>104,225,266.00</b>	<b>89,370,890.12</b>
210401	Бичиг хэрэг	3,342,800.00	4,120,100.00
210402	Тээвэр, шатахуун	5,798,600.00	4,745,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	395,470.00	343,811.00
210404	Ном, хэвлэл	63,000.00	124,340.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,290,200.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,731,148.00	7,222,219.00
210408	Бараа материал акталсны зардал	85,604,048.00	0.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	0.00	72,574,520.12
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,142,000.00</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	3,142,000.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>381,625,480.00</b>	<b>300,941,502.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	381,405,480.00	299,704,306.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	220,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	689,240.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	207,956.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	90,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>22,385,497.86</b>	<b>34,073,825.79</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	79,000.00	540,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,691,650.00	4,019,591.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,614,847.86	29,514,234.79
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,608,651,005.85</b>	<b>1,755,161,717.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,549,831,493.00</b>	<b>1,735,568,725.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	781,444,669.00	861,656,391.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	767,681,824.00	873,348,334.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	705,000.00	564,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>58,819,512.85</b>	<b>19,592,992.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	58,819,512.85	19,592,992.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>85,556,758.14</b>	<b>462,928,257.21</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>8,375,591.10</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	8,375,591.10
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>0.00</b>	<b>-8,375,591.10</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>85,556,758.14</b>	<b>454,552,666.11</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,450,358,450.00</b>	<b>2,478,337,306.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,450,358,450.00</b>	<b>2,478,337,306.00</b>

**Аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,241,496,900.00	2,130,875,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,241,496,900.00	2,130,875,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	208,861,550.00	347,461,406.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	45,086,550.00	124,337,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	135,000,000.00	22,642,050.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,525,000.00	182,113,342.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,250,000.00	18,368,314.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,428,075,450.00</b>	<b>2,455,188,906.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,428,075,450.00</b>	<b>2,455,188,906.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>792,119,508.15</b>	<b>672,789,189.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>285,790,153.00</b>	<b>271,466,419.00</b>
210101	Үндсэн цалин	210,667,261.00	200,180,745.00
210102	Нэмэгдэл	54,589,392.00	48,987,213.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,140,900.00	15,974,453.00
210104	Урамшуулал	8,392,600.00	6,324,008.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,986,605.15</b>	<b>36,655,412.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,016,117.76	26,227,676.21
210202	Тэтгэмжийн даатгал	2,784,440.08	2,401,149.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,227,674.78	1,646,580.50
210204	Ажилгүйдлийн даатгал	541,379.21	1,153,366.03
210205	Эрүүл мэндийн даатгал	5,416,993.32	5,226,639.84
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>46,263,350.00</b>	<b>46,003,700.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,033,300.00	0.00
210302	Түлш, халаалт	1,857,950.00	1,363,700.00
210303	Цэвэр, бохир ус	864,000.00	0.00
210304	Байрны түрээс	41,508,100.00	44,640,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,705,270.00</b>	<b>4,949,522.00</b>
210401	Бичиг хэрэг	530,700.00	453,700.00
210402	Тээвэр, шатахуун	2,668,500.00	2,268,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	581,270.00	529,111.00
210404	Ном, хэвлэл	128,400.00	199,340.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,270,800.00	1,114,971.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	525,600.00	384,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>388,349,380.00</b>	<b>304,933,202.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	388,349,380.00	303,664,406.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	689,240.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	239,556.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	90,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,024,750.00</b>	<b>8,780,934.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	434,100.00	250,900.00

**Аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,590,650.00	8,530,034.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,635,955,941.85</b>	<b>1,782,399,717.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,558,776,615.00</b>	<b>1,735,568,725.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	781,444,669.00	861,656,391.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	776,626,946.00	873,348,334.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	705,000.00	564,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>77,179,326.85</b>	<b>46,830,992.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	77,179,326.85	46,830,992.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>22,283,000.00</b>	<b>23,148,400.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>22,283,000.00</b>	<b>23,148,400.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>22,283,000.00</b>	<b>23,148,400.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>22,283,000.00</b>	<b>23,148,400.00</b>
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	22,283,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	23,148,400.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-22,283,000.00</b>	<b>-23,148,400.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	260,916,977.83	17,822,717.14	-40,892,425.01	237,847,269.96
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	260,916,977.83	17,822,717.14	-40,892,425.01	237,847,269.96
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	260,916,977.83	17,822,717.14	-40,892,425.01	237,847,269.96
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	163,023,000.00	0.00	0.00	163,023,000.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	85,555,758.14	85,555,758.14
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	423,939,977.83	17,822,717.14	44,664,333.13	486,427,028.10
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	423,939,977.83	17,822,717.14	44,664,333.13	486,427,028.10
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	423,939,977.83	17,822,717.14	44,664,333.13	486,427,028.10
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	423,939,977.83	17,822,717.14	44,664,333.13	486,427,028.10
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	60,000,000.00	0.00	0.00	60,000,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	454,552,666.11	454,552,666.11
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	907,879,955.66	35,645,434.28	543,881,332.37	1,000,979,694.21

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,130,875,900.00</b>	<b>2,111,291,408.00</b>	<b>-19,584,492.00</b>	<b>99.08</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,130,875,900.00</b>	<b>2,111,291,408.00</b>	<b>-19,584,492.00</b>	<b>99.08</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>377,774,400.00</b>	<b>375,722,683.00</b>	<b>-2,051,717.00</b>	<b>99.46</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>273,251,000.00</b>	<b>271,466,419.00</b>	<b>-1,784,581.00</b>	<b>99.35</b>
210101	Үндсэн цалин	199,391,900.00	200,180,745.00	788,845.00	100.40
210102	Нэмэгдэл	56,794,500.00	48,987,213.00	-7,807,287.00	86.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,672,000.00	15,974,453.00	3,302,453.00	126.06
210104	Урамшуулал	4,392,600.00	6,324,008.00	1,931,408.00	143.97
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,888,800.00</b>	<b>36,655,412.00</b>	<b>-233,388.00</b>	<b>99.37</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,708,700.00	26,227,676.21	-481,023.79	98.20
210202	Тэтгэмжийн даатгал	2,545,000.00	2,401,149.42	-143,850.58	94.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,036,000.00	1,646,580.50	-389,419.50	80.87
210204	Ажилгүйдлийн даатгал	509,000.00	1,153,366.03	644,366.03	226.59
210205	Эрүүл мэндийн даатгал	5,090,100.00	5,226,639.84	136,539.84	102.68
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>46,003,700.00</b>	<b>46,003,700.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	452,600.00	0.00	-452,600.00	0.00
210302	Түлш, халаалт	822,300.00	1,363,700.00	541,400.00	165.84
210303	Цэвэр, бохир ус	1,468,800.00	0.00	-1,468,800.00	0.00
210304	Байрны түрээс	43,260,000.00	44,640,000.00	1,380,000.00	103.19
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,950,700.00</b>	<b>4,949,522.00</b>	<b>-1,178.00</b>	<b>99.98</b>
210401	Бичиг хэрэг	453,700.00	453,700.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	2,268,200.00	2,268,200.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	529,200.00	529,111.00	-89.00	99.98
210404	Ном, хэвлэл	200,200.00	199,340.00	-860.00	99.57
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, арнутгал	1,115,200.00	1,114,971.00	-229.00	99.98
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	384,200.00	384,200.00	0.00	100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,249,200.00</b>	<b>7,216,696.00</b>	<b>-32,504.00</b>	<b>99.55</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,947,900.00	5,947,900.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	696,300.00	689,240.00	-7,060.00	98.99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	265,000.00	239,556.00	-25,444.00	90.40

**Аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	90,000.00	90,000.00	0.00	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,431,000.00</b>	<b>9,430,934.00</b>	<b>-66.00</b>	<b>100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	250,900.00	250,900.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,180,100.00	9,180,034.00	-66.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,753,101,500.00</b>	<b>1,735,568,725.00</b>	<b>-17,532,775.00</b>	<b>99.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,753,101,500.00</b>	<b>1,735,568,725.00</b>	<b>-17,532,775.00</b>	<b>99.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	879,148,600.00	861,656,391.00	-17,492,209.00	98.01
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	873,388,900.00	873,348,334.00	-40,566.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	564,000.00	564,000.00	0.00	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,130,875,900.00</b>	<b>2,111,291,408.00</b>	<b>-19,584,492.00</b>	<b>99.08</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,130,875,900.00</b>	<b>2,111,291,408.00</b>	<b>-19,584,492.00</b>	<b>99.08</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,130,875,900.00	2,111,291,408.00	-19,584,492.00	99.08
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>20.00</b>	<b>20.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	0.00	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>208,861,550.00</b>	<b>347,461,406.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>208,861,550.00</b>	<b>320,214,906.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>208,861,550.00</b>	<b>320,214,906.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>208,861,550.00</b>	<b>320,214,906.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	208,861,550.00	320,214,906.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>27,246,500.00</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	27,246,500.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>208,861,550.00</b>	<b>347,461,406.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>208,861,550.00</b>	<b>347,461,406.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	45,086,550.00	124,337,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	135,000,000.00	22,642,050.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,525,000.00	182,113,342.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,250,000.00	18,368,314.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 84 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд газрын дарга Ц.Энхтөр нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Л.Оюунтуяа хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

“Төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн чадварыг сайжруулах олон талт арга хэмжээг зохион байгуулах, Боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээлч багшийг бий болгож, “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлнэ. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах боломжоор хангах, сургууль орчны нэвтрэлт бүртгэлийн системийг шинээр нэвтрүүлнэ” гэсэн зорилготой ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/37 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөж байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг БШУЯ-ны Хяналт шинжилгээний үнэлгээ дотоод аудитын газар нь хэрэгжүүлдэг ба Аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,493,005.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 24,930.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17,451.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 17,667.3 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,001,740.5 мянган төгрөг болж өмнөх оноос 515,313.5 мянган төгрөгөөр буюу 51.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	168,311.2	174,507.2	6,196.0
Мөнгөн хөрөнгө	-	-	0.0
Авлага	18,607.3	27674.6	9,067.3
Урьдчилгаа	-	-	0.0
Бараа материал	149,703.9	146,831.0	-2,872.9
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	318,115.7	827,233.3	509,117.6
Үндсэн хөрөнгө	506,285.3	1,000,832.0	494,546.7
Хуримтлагдсан элэгдэл	-188,169.6	-173,598.6	14,571.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>486,427.0</b>	<b>1,001,740.5</b>	<b>515,313.5</b>
Өр төлбөр	0.1	760.9	760.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	486,427.0	1,000,979.6	514,552.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>486,427.0</b>	<b>1,001,740.5</b>	<b>515,313.5</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 146,831.0 мянган төгрөг болж 2,872.9 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал өмнөх оноос 4,001.6 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 540.0 мянган төгрөгөөр буурсан ба БСШУЯ-наас шилжүүлж ирсэн 72,574.5 мянган төгрөгийн сурах бичгүүдийг хүлээн авч орлогоор бүртгэсэн нь бараа материал голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,000,832.0 мянган төгрөг болж 494,546.7 мянган төгрөгөөр өссөн нь БСШУ яамнаас шилжиж ирсэн 5,861.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 495,556.1 мянган төгрөгийн Номгон ахлах сургуулийн хичээлийн 2-р байр, 60,000.0 мянган төгрөгийн газрын хамт балансаас шилжүүлэн авсан байна. Мөн төсвийн хөрөнгөөр 23,148.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271-р тогтоолын 4.1.1-д заасны дагуу холбогдох дансанд бүртгэж 45,014.0 мянган төгрөгийн хөрөнгийг Насан туршийн боловсролын төвд шилжүүлэн өгсөн, 72,574.5 мянган төгрөгийн сурах бичгийн аймгийн ерөнхий боловсролын сургуулиудад тараан өгсөн, 55,005.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Тайлант онд 27,674.6 мянган төгрөгийн авлага үүссэн нь НҮБ-ын хүүхдийн сангийн хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдэх төсөл арга хэмжээний тендер зарлагдах хугацаатай холбоотойгоор тус төслийн зардлыг санхүүжилтийн авлага үүсгэж бүртгэл тайланд тусгасан байна. Мөн 760.9 мянган төгрөгийн өглөг үүссэн нь боловсролын салбар үүсэн байгууллагдсаныг 100 жилийн ойд зориулан гарсан сонины төлбөр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,000,979.6 мянган төгрөг болж 514,552.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 454,552.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,615,590.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,615,590.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 494,516.0 мянган төгрөгөөр өсгөж 2,110,106.9 мянган төгрөгөөр анх батлагдсан ба 2021 оны 12 дугаар сард төсөвт зохицуулалт хийгдэж 2,130,875.9 мянган төгрөг болж 20,769.0 мянган төгрөг буюу 0.9 хувиар нэмж тодотгосон байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,130,875.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,130,875.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,111,291.4 мянган төгрөгийг зарцуулж 19,584.4 мянган төгрөг буюу 0.9 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,111,291.4 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 1,784.5 мянга, НДШ-ын

зардал 233.3 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулал 17,492.2 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 40.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банкин дахь 100030015401 тоот дансанд НҮБ-ын хүүхдийн сангаас 116,104.1 мянга, Жайка олон улсын төслөөс 8,233.5 мянга, аймгийн ЗДТГ-аас 22,642.0 мянга, БСШУЯ-наас хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт 16,295.0 мянга, ариутгал халдваргүйжүүлэлтийн санхүүжилт 18,136.8 мянга, цахим контент тахим байгуулах хөрөнгийн санхүүжилт 19,000.0 мянга, ЕБС-ын түвшин тогтоох шалгалтын бичиг хэргийн зардлын санхүүжилт 9,577.5 мянга, Боловсролын чанарын шинэчлэлт төслийн санхүүжилт 119,104.0 мянга нийт 347,461.4 мянган төгрөгийг тус тус орж ирснийг БСШУ-ны сайдын 2021 оны 08 дугаар сарын 12-ны А/279 дүгээр тушаалын дагуу ЕБС, СӨБ-ын хичээлийн болон дотуур байрыг мэргэжлийн байгууллагатай хамтран ариутгал халдваргүйжүүлэлтийг хийхийг даалгасны дагуу санхүүжилтийг “АКОС “ХХК-д 7,048.0 мянга, “Номгон ариусал” ХХК-д 6,538.8 мянга, “Бурхант эх” ХХК-д 4,550.0 мянган төгрөгийг 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 04,05,06 тоот ажил гүйцэтгэх гэрээг хийж санхүүжилтийг олгосон байна. Мөн БСШУ-ны сайдын 2021 оны 08 дугаар сарын 12-ны А/280 тоот тушаалын дагуу тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилтийг төсөл нь шалгарсан нэр бүхий аймгийн төвийн болон сумдын 18 ЕБС-ын нэмэлт санхүүжилтийн дансанд жагсаалтын дагуу 119,104.0 мянга, БСШУЯ-наас хүүхэд харах үйлчилгээний 6 аж, ахуй нэгжийн 14 багшийн цалингийн зардлын санхүүжилт 16,295.0 мянга, БСШУ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны А/397, 2021 оны 11 дүгээр сарын 25-ны А/24 тоот тушаалыг тус тус үндэслэн цахим контент танхим байгуулах хөрөнгийн санхүүжилт 19,000.0 мянган төгрөг олгосон, ЕБС-ын түвшин тогтоох шалгалтын бичиг хэргийн зардлын санхүүжилт 9,577.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн чадварыг сайжруулах олон талт арга хэмжээг зохион байгуулах, Боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээлч багшийг бий болгож, “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлнэ. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах боломжоор хангах, сургууль орчны нэвтрэлт бүртгэлийн системийг шинээр нэвтрүүлнэ.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 86 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 91,9%-тай гэж тайлагнасан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 2,533,482.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 40,477.0 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал өмнөх оноос өссөн бол бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн системд нийт 2,130,875.9 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс 184,313.9 мянган төгрөгийн 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### **3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Урсгал төсвийн зарцуулалт нь гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,130,875.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,111,291.4 мянган төгрөгийг зарцуулж 19,584.4 мянган төгрөг буюу 0.9 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд тогтмол зардалд 46,003.7 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 9,200.7 мянган төгрөг байна. Тус онд байр ашиглалтын түрээсийн зардлаас хэмнэлт үүсээгүй байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай бүрэн нийцэхгүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 42,739.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3,097.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 2,260.8 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 37,380.3 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 заалт бүхий зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллаж хэрэгжилтийн тайланг 2021 оны 06 дүгээр сарын 14-ны өдрийн 53 тоот албан бичгээр ирүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах аяны хүрээнд шалгасан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын тухай хуулийн 43.1.4, 43.1.7 дахь заалтын дагуу олгогдож буй тэтгэмжийн зардалд тус байгууллыг тайлант оны төсөвт төгрөг батлагдсан ирж холбогдох баримт материалын үндэслэн байгууллага тус бүрийн нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүжилтийг олгож байна. Санхүүгийн тайлангийн аудитын цаглаварт хугацаанд Тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн тэтгэмж урамшуулал, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгодог тэтгэмж урамшууллыг холбогдох байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосон. Харин тэтгэмжийн тогтоолтыг санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримттай тулган үзэх боломжгүй байсан болно.

№	Тэтгэмжийн нэр	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл		Зөрүү	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51	879,148.60	49	861,656.30	2	17,492.30
2	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгодог тэтгэмж урамшуулал	192	873,388.90	190	873,348.30	2	40.60
<b>Нийт</b>		<b>243</b>	<b>1,752,537.50</b>	<b>239</b>	<b>1,735,004.60</b>	<b>4</b>	<b>17,532.90</b>

Дээрх 2 хүний 17,492.3 мянган төгрөгийн хэмнэлтийг улсын төсөвт төвлөрүүлсэн болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 240,542.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч 220,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 20,542.5 мянган төгрөгийн 3 заалт бүхий зөвлөмжийг хүргүүллээ.

### 4.1 Албан шаардлага

4.1.1 Тус газраас 2020 онд ерөнхий боловсролын 26 сургуульд Онлайн кабинет төслийн хүрээнд нийлүүлэгдсэн ухаалаг самбарыг Санко Маркетинг Монголиа ХХК-аас 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01/169 тоот албан бичгээр дахин нийлүүлэх хамтран ажиллах хүсэлтийг аймгийн БСУГ-т ирүүлсэн байна. Тус хүсэлтийн дагуу БСУГ-аас аймгийн Засаг даргад 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 375 тоот албан бичгээр сургуулиудаас хүрэлцээ хангамжийн хувьд дутагдалтай байгаа, суралцагч, багшийн тоотой уялдуулан тус самбарыг нэмэгдүүлэх хүсэлтийг ирүүлсэн байна.

Дээрх ухаалаг самбарыг нийлүүлэх санхүүжилтийг тус салбарт тайлант онд хэмнэгдэж буй үдийн цай, хүүхдийн хоол, тогтмол зардлын хэмнэлтэд зохицуулалт хийж тухайн сургууль бүрд 12 дугаар сарын хуваарьт нэмж өөрчлөлт оруулан төлөвлөн батлуулсан байгаа нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу хэмнэлт үүсэх боломжтой байсан зардлуудыг зохицуулалт хийлгэж зарцуулсан байна. Сургууль бүрийн төсөвт санхүүжилтийг тендерийн босго үнээс доогуур байдлаар хуваарилуулан худалдан авалтыг нэг аж ахуй нэгжээс хийж байгаа нь тус байгууллагад давуу тал олгож байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.2.5. "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх", Засгийн газрын 2021 оны 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1 "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

**Шийдвэрлэсэн:** Цаашид хууль тогтоомж болон Засгийн газрын тогтоол болон дээд шатны байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөн ажиллах.

#### 4.2 Зөвлөмж

4.2.1 Мөнгөн хөрөнгийн 62 харилцагчтай холбоотой 369,795.5 мянган төгрөгийн худалдан авалтын гүйлгээг татварын цахим системд бүртгэгдсэн төлбөрийн баримттай тулгахад 8 харилцагчтай холбоотой 11,341.8 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримтыг харилцагчаас гаргуулан аваагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Худалдан авалтын гүйлгээний 11,341.8 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг гаргуулан авч төлбөр тооцоог хийж, тулган баталгаажуулж, цаашид Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллах.

4.2.2 Тайлант онд тогтмол зардалд 46,003.7 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь болох 9,200.7 мянган төгрөгийн хэмнэлт үүсээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын "1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалтыг зөрчиж байна.

**Шийдвэрлэсэн:** Цаашид Засгийн газрын тогтоол болон дээд шатны байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөн ажиллах.

4.2.3 Тус байгууллага нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн системд нийт 2,130,875.9 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, төсвийн төсөл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, худалдан авах ажиллагаа болон арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, .. гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах.. шийдвэр, орон тооны өөрчлөлт зэрэг 184,313.9 мянган төгрөгийн 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.6, 6.4.4, 6.4.5, 6.4.7, 6.4.8 гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1.3, 6.1.6, 6.4.4, 6.4.5, 6.4.7, 6.4.8 дахь хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, хугацаанд нь үнэн зөв мэдээлж, хуулийг хэрэгжүүлж ажиллаж байгаад тавих удирдлагын дотоод хяналтыг сайжруулах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Боловсрол соёл, урлагийн газрын	4	240,542.5	0	0	0	0	1	220,000.0	3	20,542.5

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_